



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 04 өдөр

Дугаар А/460

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.11, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Үйлдвэрлэл үйлчилгээ худалдааны “ХБС” ХХК-ийн 2023 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн “Тендер шалгаруулалтын тухай” 105 тоот албан бичгээр ирүүлсэн гомдолд дурдсан асуудлыг судалж, шийдвэрлүүлэх чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Болд (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын
Худалдан авах ажиллагааны албаны дарга)

Гишүүдэд: Ш.Дамдиндорж (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Х.Буянтогтох (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

М.Батчимэг (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга: Х.Цэнд-Аюуш (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Ахлах мэргэжилтэн)

2. Дээрх албан бичигт дурдсан асуудлыг 2023 оны 09 дүгээр сарын 08-ны өдрийн дотор судалж, танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч (Б.Болд)-д үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т даалгасугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ



Захирамж-2023

671 010973